



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ\*

2019 оны 2 дугаар сар


**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 2 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23%-иар буюу 367 сая ам.доллараар өсч 1,931 сая ам.доллар байв. Үүнд экспорт 30%-иар буюу 255 сая ам.доллараар, импорт 15%-иар буюу 111 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 144 сая ам.доллараар өсч 256 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 2 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	1,299	1,564	1,931	265	20%	367	23%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	812	838	1,094	26	3%	255	30%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	487	726	838	239	49%	111	15%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	326	112	256	(213)	-65%	144	128%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл\*\*** 2019 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 137 сая ам.доллараар өсч 287 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 56% буюу 1,075 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 13% буюу 256 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 2%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 14%-иар тус тус өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 2019 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.1%-иар, өмнөх сараас 3.4%-иар буурч 1.681-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас муудахад хөрөнгө оруулалтын барааны импортын үнийн өсөлт голлон нөлөөлөв.

\*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

\*\* Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

**Экспорт** 2019 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 30%-иар буюу 255 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 31 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурсан байна.

**Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>1. Уул уурхай</b>		<b>758</b>	<b>92%</b>	<b>762</b>	<b>91%</b>		<b>1,018</b>	<b>93%</b>		<b>4</b>	<b>1%</b>	<b>0%</b>	<b>256</b>	<b>34%</b>	<b>31%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	241	246	30%	205	275	33%	229	309	28%	28	11%	3%	34	13%	4%
1.2. Чулуун нүүрс	4,792	326	39%	3,149	242	29%	4,025	332	30%	(83)	-26%	-10%	90	37%	1%
1.3. Боловсруулаагүй нефть	1,126	59	7%	1,010	63	7%	1,011	53	5%	4	7%	0%	(10)	-15%	-1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	713	45	5%	932	40	5%	1,181	52	5%	(5)	-12%	-1%	13	32%	2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	778	31	4%	1,696	72	9%	4,665	196	18%	41	135%	5%	124	171%	15%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	19	27	3%	21	37	4%	25	34	3%	10	38%	1%	(3)	-7%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	33	8	1%	49	16	2%	69	23	2%	8	103%	1%	8	49%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	6	1%	1	6	1%	1	8	1%	0	7%	0%	2	35%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	1	0%	0	0	0%	0	0%	0%	(0)	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	-	0%	0	0	0%	0	-	0%	0	0%	0%	(0)	0%	0%
1.11. Бусад	83	10	1%	106	11	1%	54	9	1%	0	0%	0%	(2)	-17%	0%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>82</b>	<b>29</b>	<b>4%</b>	<b>87</b>	<b>29</b>	<b>4%</b>	<b>72</b>	<b>32</b>	<b>3%</b>	<b>0</b>	<b>2%</b>	<b>0%</b>	<b>2</b>	<b>7%</b>	<b>0%</b>
2.1. Амьд мал, малын мах	2	4	0%	5	11	1%	5	10	1%	7	195%	1%	(1)	-12%	0%
2.2. Арьс, шир	77	7	1%	80	5	1%	63	3	0%	(3)	-37%	0%	(2)	-38%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	1	0%	0	1	0%	0	1	0%	0	0%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	1	15	2%	1	11	1%	1	12	1%	(4)	-29%	-1%	1	12%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	1	2	0%	1	2	0%	2	5	0%	(0)	-16%	0%	4	227%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	47%	0%	(0)	-19%	0%
<b>3. Газар тариалан</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>11</b>	<b>3</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-41%</b>	<b>0%</b>	<b>2</b>	<b>424%</b>	<b>0%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>66</b>	<b>38</b>	<b>5%</b>	<b>11</b>	<b>47</b>	<b>6%</b>	<b>74</b>	<b>41</b>	<b>5%</b>	<b>9</b>	<b>24%</b>	<b>1%</b>	<b>(5)</b>	<b>-11%</b>	<b>-1%</b>
4.1. Хүнс	3	10	1%	5	17	2%	6	15	1%	7	66%	1%	(2)	-11%	0%
4.2. Ноолууран адал	0	3	0%	0	3	0%	0	6	1%	1	27%	0%	3	82%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, адал	0	2	0%	1	2	0%	0	2	0%	1	26%	0%	(1)	-37%	0%
4.4. Уул уурхай	6	18	2%	4	17	2%	17	14	1%	(0)	-3%	0%	(3)	-19%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	303%	0%	(0)	-26%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	0	4	0%	0	5	1%	0	4	0%	2	39%	0%	(2)	-35%	0%
4.7. Бусад	58	1	0%	0	1	0%	51	1	0%	(0)	-8%	0%	0	0%	0%
<b>5. Бусад</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-27%</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>0%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>825</b>		<b>838</b>			<b>1,094</b>			<b>13</b>	<b>2%</b>		<b>255</b>	<b>30%</b>	

%<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 2 сар**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>244</b>		<b>12</b>		<b>256</b>	<b>34%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	33	95%	2	5%	34	13%
1.2. Чулуун нүүрс	72	80%	18	20%	90	37%
1.3. Боловсруулаагүй нефть	0	-1%	(10)	101%	(10)	-15%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	11		2		13	32%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	125	101%	(1)	-1%	124	171%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	5	-179%	(8)	279%	(3)	-7%
1.7. Жонош, лейцит, нефелинт	7	86%	1	14%	8	49%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(0)	-5%	2	105%	2	35%
1.11. Бусад	(8)	488%	7	-388%	(2)	-17%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>1</b>		<b>1</b>		<b>2</b>	<b>7%</b>
2.1. Амьд мал, малын мах	(0)	6%	(1)	94%	(1)	-12%
2.2. Арьс, шир	(1)	44%	(1)	56%	(2)	-38%
2.3. Малын өлөн гэдэс	(0)	-40%	1	140%	0	0%
2.4. Ноолуур	(1)	-92%	2	192%	1	12%
<b>3. Газар тариалан</b>	<b>2</b>		<b>(0)</b>		<b>2</b>	<b>5х</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>10</b>		<b>(15)</b>		<b>(5)</b>	<b>-11%</b>
<b>5. Бусад</b>	<b>0</b>		<b>(0)</b>		<b>(0)</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>257</b>		<b>(2)</b>		<b>255</b>	<b>30%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2019 оны эхний 2 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 257 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 2 сая ам.доллараар буурлаа. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 105 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 19 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 10 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 15 сая ам.доллараар буурсан байна.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 2 дугаар сард 1,319 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 0.9%-иар буурсан хэдий ч өмнөх сараас 2.1%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,300; 88 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 10.1%-иар буурсан бол төмрийн хүдэр 13.9%-иар, өнгөрсөн сараас зэс 6.1%-иар, төмрийн хүдэр 15.8%-иар тус тус өссөн. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 2 дугаар сард 86 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1.7%-иар буурсан хэдий ч өмнөх сараас 7.1%-иар өслөө.

**Импорт** 2019 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 15%-иар буюу 111 сая ам.доллараар өсөв. Импортын 15 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 13 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 4.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%?	Дүн	Өсөлт	%?
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>159</b>	<b>32%</b>		<b>209</b>	<b>29%</b>		<b>236</b>	<b>28%</b>	<b>50</b>	<b>31%</b>	<b>10%</b>	<b>26</b>	<b>13%</b>	<b>4%</b>
Түргэн эдэлгээтэй	148	91	19%	137	115	16%	118	111	13%	24	26%	5%	(4)	-3%	0%
Хүнс	47	59	12%	64	81	11%	55	78	9%	21	36%	4%	(3)	-4%	0%
Эм, тариа	0	14	3%	0	14	2%	0	14	2%	1	5%	0%	(1)	-4%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	101	18	4%	72	20	3%	63	20	2%	2	9%	0%	0	0%	0%
Удаан эдэлгээтэй	43	68	14%	22	94	13%	27	124	15%	26	39%	5%	30	32%	4%
Гутал, хувцас, цунх	13	7	1%	7	10	1%	9	8	1%	2	32%	0%	(1)	-14%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	21	16	3%	7	18	2%	8	16	2%	2	11%	0%	(2)	-9%	0%
Авто машин, түүний салбэр хэрэгсэл	0	37	8%	0	55	8%	0	89	11%	18	48%	4%	34	61%	5%
Бусад удаан эдэлгээтэй бараа	9	7	1%	7	11	2%	9	11	1%	4	56%	1%	(1)	-5%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>126</b>	<b>162</b>	<b>33%</b>	<b>243</b>	<b>242</b>	<b>33%</b>	<b>188</b>	<b>334</b>	<b>40%</b>	<b>80</b>	<b>50%</b>	<b>16%</b>	<b>91</b>	<b>38%</b>	<b>13%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	5	122	25%	3	155	21%	4	257	31%	32	26%	7%	102	66%	14%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	18	4%	0	48	7%	1	95	11%	29	163%	6%	47	99%	6%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	5	104	21%	3	107	15%	3	163	19%	3	3%	1%	55	52%	8%
Барилгын материал	28	24	5%	47	51	7%	60	57	7%	27	115%	5%	6	12%	1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	4	16	3%	5	37	5%	3	20	2%	21	130%	4%	(17)	-46%	-2%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>176</b>	<b>66</b>	<b>13%</b>	<b>236</b>	<b>115</b>	<b>16%</b>	<b>300</b>	<b>86</b>	<b>10%</b>	<b>49</b>	<b>75%</b>	<b>10%</b>	<b>(30)</b>	<b>-26%</b>	<b>-4%</b>
Хүнсний орц	6	2	0%	71	27	4%	4	2	0%	25	1121%	5%	(25)	-91%	-3%
Химийн бүтээгдэхүүн	19	11	2%	29	16	2%	32	17	2%	5	47%	1%	1	5%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	3	3	1%	7	3	0%	16	5	1%	1	24%	0%	1	37%	0%
Цахилгаан эрчим хүч	0	21	4%	0	23	3%	0	14	2%	2	12%	1%	(9)	-39%	-1%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	91%	0%	(0)	-60%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	97	29	6%	135	45	6%	136	48	6%	16	54%	3%	2	5%	0%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>176</b>	<b>102</b>	<b>21%</b>	<b>236</b>	<b>157</b>	<b>22%</b>	<b>300</b>	<b>181</b>	<b>22%</b>	<b>55</b>	<b>54%</b>	<b>11%</b>	<b>24</b>	<b>15%</b>	<b>3%</b>
Дизель түлш	99	53	11%	151	97	13%	181	111	13%	44	82%	9%	14	14%	2%
АИ-92, АИ-95	53	32	7%	47	33	5%	86	47	6%	1	2%	0%	14	42%	2%
А-80 болон бусад	23	17	3%	39	27	4%	33	23	3%	11	65%	2%	(4)	-14%	-1%
<b>Бусад</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>23</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>10%</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-20%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>491</b>		<b>726</b>			<b>838</b>			<b>235</b>	<b>48%</b>		<b>111</b>	<b>15%</b>	

%? - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 5.** Импортын өөрчлөлт, 2019 он эхний 2 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	16	60%	11	40%	26	13%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	64	71%	27	29%	91	38%
Аж үйлдвэрлэлийн орц	(45)		15		(30)	-26%
Нефтийн бүтээгдэхүүн	36	150%	(12)	-50%	24	15%
Дизель түлш	19	134%	(5)	-34%	14	14%
АИ-92, АИ-95	21	154%	(7)	-54%	14	42%
А-80 болон бусад	(4)	104%	0	-4%	(4)	-14%
Бусад	1		(1)		(0)	-20%
<b>Нийт дүн</b>	<b>72</b>	<b>65%</b>	<b>39</b>	<b>35%</b>	<b>111</b>	<b>15%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 91 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 26 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 24 сая ам.доллараар өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 30 сая ам.доллараар буурснаар нийт импорт 111 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар буурч тонн тутамд 604 ам.долларт хүрэв.